# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
# ТУШААЛ

2020 оны 02 сарын 27 өдөр Дугаар А/141 Улаанбаатар хот

ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 2 дугаар заалт, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагуудад тайлагнаж байхыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), тайлагналтад хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Нийгмийн эрүүл мэндийн газар (Т.Энхзаяа)-т даалгасугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Нийгмийн эрүүл мэндийн газар (Т.Энхзаяа), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Д.Нарантуяа), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал)-д үүрэг болгосугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

141200489

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугээр сарын
27...-ний өдрийн А/141 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## НЭГ. ХДХВ, ДОХ, БЗДХ-ААС СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөний зорилго ХДХВ, ДОХ, БЗДХ-ын мэдээг үнэн зөв, шуурхай байдлыг ханган, үр дүнтэй цуглуулж, дүн шинжилгээ хийж, түгээснээр ХДХВ, ДОХ, БЗДХ-ын үндэсний хариу арга хэмжээг оновчтой болгох, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргахад хувь нэмэр оруулахад оршино.

Дээрхи зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг тодорхой болгосноор мэдээ цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлбарлах үйл ажиллагааг сайжруулах;
- Үндсэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;
- ХДХВ, ДОХ, БЗДХ-тай холбоотой үндэсний хэмжээнд хийгдэж буй судалгааны практик ач холбогдлыг дээшлүүлэх;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээнд шаардлагатай мэдээний эх үүсвэрийг тодорхойлох;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээнд оролцогч талуудын чадавхийг сайжруулах;
- Хэрэгжүүлэгч байгууллага, түншлэгч, хамтрагч байгууллагууд болон нийт хүн амд түгээх мэдээллийн агуулга, арга замыг тодорхойлох;
- Олон улсын түвшинд ХДХВ, ДОХ, БЗДХ-тай холбоотой тайлагналтыг сайжруулах.

Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.5.3.1.2-т БЗДХ, ХДХВ, ДОХ-ын Үндэсний хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө боловсруулж, мөрдөн ажиллахаар тусгасан.

ХДХВ, ДОХ, БЗДХ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ нь үндэсний түвшинд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, холбогдох бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, зарцуулагдаж буй нөөц, хүрсэн үр дүнг тооцох багц шалгуур үзүүлэлт, тэдгээрийн зорилтоос бүрдэнэ.

## 1.1. ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд нь ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх, эмчилгээ, тусламж, үйлчилгээний хүртээмж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ болон ХДХВ, ДОХ-ын асуудлаарх тунхаглалын үүрэг амлалтын хэрэгжилт болон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал, хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг тодорхойлох, тохируулга хийх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэглэгдэнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг Тогтвортой хөгжлийн зорилт, төрийн бодлого, үндэсний хөтөлбөр болон НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөр, Глобаль сангийн ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх төсөл, олон улсын тайлангийн шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Шалгуур үзүүлэлтийг үр нөлөөний, үр дүнгийн, гарцын гэсэн ангиллаар (А) урьдчилан сэргийлэлт, (Б) эмчилгээ, халамж, дэмжлэгийн үйлчилгээ, (В) үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний удирдлага, зохицуулалт гэсэн бүлэг тус бүрээр тооцохоор тусгагдсан болно (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлтийн ангилал, дугаар

| Шалгуур үзүүлэлтийн төрөл, дугаар | | | |
|---|---|---|---|
| | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Гарцын шалгуур үзүүлэлт |
| Урьдчилан сэргийлэлт | А1-А9 | А10- А18 | А19-А21 |
| Эмчилгээ, халамж, дэмжлэг | Б1-Б3 | Б4-Б5 | Б6-Б9 |
| Үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний удирдлага зохицуулалт | - | В1-В2 | В3-В4 |

ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн суурь үзүүлэлт, дэвшүүлсэн зорилтууд, мэдээллийн эх сурвалжийг Хүснэгт 2-т шалгуур үзүүлэлт тус бүрийн дэлгэрэнгүйг нэгтгэн харуулав.

Хүснэгт 2

## ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

| Шалгуур үзүүлэлтийн төрөл | | Дугаар | Шалгуур үзүүлэлтийн нэр | Мэдээллийн эх үүсвэр | Суурь үзүүлэлт | Зорилтот түвшин (2021 он) |
|---|---|---|---|---|---|---|
| Урьдчилан сэргийлэлт | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт | A1 | Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн дундах ХДХВ-ийн халдвартай хүний эзлэх хувь | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он - 9.2% | 7.7% |
| | | A2 | Эмэгтэй биеэ үнэлэгчдийн дундах ХДХВ-ийн халдвартай хүний эзлэх хувь | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он - 0% | 0% |
| | | A3 | Мансууруулах бодис тарьж хэрэглэгчдийн дундах ХДХВ-ийн халдвартай хүний эзлэх хувь | Тусгайлсан судалгаа | Байхгүй | 0% |
| | | A4 | Эмэгтэй биеэ үнэлэгчдийн дундах тэмбүүгийн халдварын тархалт | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он - 24.5% | 22.8% |
| | | A5 | Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн дундах тэмбүүгийн халдварын тархалт | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он - 9.2% | 8.0% |
| | | A6 | Жирэмсний хяналтад буй эмэгтэйчүүдийн дундах тэмбүүгийн халдварын тархалт | Эрүүл мэндийн статистик мэдээ | Эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он - 2.0 | 1.6 |
| | | A7 | ХДХВ-ийн халдваргүй 1 000 хүн амд ногдох ХДХВ-ийн шинэ тохиолдлын тоо (Тогтвортой хөгжлийн зорилт 3.3.1) | Эрүүл мэндийн статистик мэдээ | Эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он - 0.01 | 0.01 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Урьдчилан сэргийлэлт | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт | A8 | 15-24 насны залуучуудын дундах тэмбүүгийн тохиолдлын түвшин (10 000 хүн амд) | ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны тайлан | ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны тайлан, 2018 он – 53.1 | 50.0 |
| | | A9 | 15-34 насны залуучуудын дунд түгээмэл тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлын түвшин (10 000 хүн амд) | Эрүүл мэндийн статистик мэдээ | Эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он - 197.9 | 119.2 |
| | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | A10 | ХДХВ-ийн халдвар бэлгийн замаар дамжихаас сэргийлэх аргыг зөв тодорхойлж, ХДХВ-ийн халдварын талаарх түгээмэл ташаа ойлголтыг үгүйсгэж чадсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн эзлэх хувь | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он - 25.3% | 29.6% |
| | | A11 | ХДХВ-ийн халдвар бэлгийн замаар дамжихаас сэргийлэх аргыг зөв тодорхойлж, ХДХВ-ийн халдварын талаарх түгээмэл ташаа ойлголтыг үгүйсгэж чадсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн эзлэх хувь | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он - 55.6% | 57.7% |
| | | A12 | Сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаж, шинжилгээнийхээ хариуг мэдэж байгаа эмэгтэй биеэ үнэлэгчдийн эзлэх хувь | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он - 76.4% | 84.2% |
| | | A13 | Сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаж, шинжилгээнийхээ хариуг мэдэж байгаа эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн эзлэх хувь | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он - 87.7% | 95.0% |
| | | A14 | ХДХВ-ийн халдвар бэлгийн замаар дамжихаас сэргийлэх аргыг зөв тодорхойлж, ХДХВ-ийн халдварын талаарх түгээмэл ташаа ойлголтыг үгүйсгэж чадсан 15-24 насны залуучуудын эзлэх хувь | Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа | Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он<br>Эрэгтэй - 20.2%<br>Эмэгтэй - 20.2% | Суурь үзүүлэлтээс дээгүүр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Урьдчилан сэргийлэлт | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | А15 | Шинээр оношлогдсон сүрьеэтэй өвчтөнүүдийн дунд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн өвчтөнүүдийн эзлэх хувь | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан, мэдээ | Сүрьеэгийн төв, кабинетийн үйл ажиллагааны тайлан, 2018 он - 98.7% | 99.0% |
| | | А16 | Сүүлийн удаа эрэгтэй хүнтэй хошногоор бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн эрэгтэйчүүдийн эзлэх хувь | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он – 78.5% | 83.0% |
| | | А17 | Сүүлийн удаа үйлчлүүлэгчтэйгээ бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн ЭБҮ-ийн эзлэх хувь | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он -85.1% | 90.0% |
| | | А18 | ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн эзлэх хувь | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он - 55.2% | 90.0% |
| | Гарцын шалгуур үзүүлэлт | А19 | ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн эзлэх хувь | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны тайлан, 2017 он - 51.0% | 75.0% |
| | | А20 | ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан мансууруулах бодис тарьж хэрэглэгчдийн эзлэх хувь | - Тусгайлсан судалгаа<br>- ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа | Одоогоор байхгүй | Судалгаа хийх |
| | | А21 | Жирэмсэн эмэгтэйчүүдийн тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдалтын хувь | Эрүүл мэндийн статистик мэдээ | Эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 он - 97.7% | 98.4% |
| Эмчилгээ, халамж, дэмжлэг | Үр нөлөөний шалгууур үзүүлэлт | Б1 | ХДХВ-ийн халдвартай эхээс төрсөн бөгөөд төрснөөс хойш эхний хоёр сарын дотор ХДХВ илрүүлэх шинжилгээ хийлгэсэн хүүхдийн хувь | ХӨСҮТ, ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны тайлан | GAM тайлан, 2017 он - 100% | 100% |
| | | Б2 | Ретровирусийн эсрэг эмчилгээнд хамрагдах заалттай ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн эмчилгээнд хамрагдсан байдал | ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны гайлан | GAM тайлан, 2017 он - 90.0% | 90.0% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Б3 | ХДХВ, сүрьеэгийн хавсарсан халдвартай бөгөөд сүрьеэгийн эмчилгээний хажуугаар РВЭЭ хийлгэж буй өвчтөний эзлэх хувь | ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны тайлан | | 100% |
| Эмчилгээ, халамж, дэмжлэг | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Б4 | Ретровирүсийн эсрэг эмчилгээ хийлгэж эхэлснээс хойш 12 сар ба түүнээс дээш хугацаагаар эмчилгээгээ үргэлжлүүлэн хийлгэж байгаа ХДХВ-ийн халдвартай хүүхэд, насанд хүрэгсдийн эзлэх хувь | ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны тайлан | GAM тайлан, 2018 он - 81.8% | 95% |
| | | Б5 | Ретровирүсийн эсрэг эмчилгээ авч байгаа ХДХВ-ийн халдвартай хүний эзлэх хувь | ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны тайлан<br>ХДХВ, ДОХ-ын тооцоолол тайлан | ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, тусламж, үйлчилгээний үндэсний хариу арга хэмжээний ахиц дэвшлийн тайлан, 2017 он - 18.54% | 50.0% |
| | Гарцын шалгуур үзүүлэлт | Б6 | Ретровирүсийн эсрэг эмчилгээ хийдэг эрүүл мэндийн байгууллага/ эмнэлгүүдийн эзлэх хувь | ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны тайлан | GAM тайлан, 2017 он - 20.6% | Суурь үзүүлэлтээс дээгүүр |
| | | Б7 | ХДХВ-ийн халдвар илрүүлэх зөвлөгөө, шинжилгээний үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ, ЭМГ) | Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, 2016 он - 44<br>Улсын байгууллага - 30<br>Хувийн хэвшлийн байгууллага - 14 | Суурь үзүүлэлтээс дээгүүр |
| | | Б8 | Лабораторийн шинжилгээгээр ХДХВ-ийн халдвар авсан нь тогтоогдсон хүмүүсийн хариугаа авсан хүний эзлэх хувь | ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны тайлан | Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр, 2015 он - 48.0% | 90.0% |
| | | Б9 | ХДХВ-ийн халдвартай гэдгээ мэдэж байгаа ХДХВ-ийн халдвартай амьдарч байгаа хүний эзлэх хувь | ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны тайлан | GAM тайлан, 2017 он - 32.3% | 50.0% |
| Үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй арга | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | В1 | Улсын төсөв болон олон улсын байгууллагаас ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, эмчилгээ, тусламж, үйлчилгээ болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан зардал | ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, бууруулахад чиглэсэн үндэсний хариу арга хэмжээнд зарцуулсан зардлын үнэлгээ | 2016 он – 8,320,395.4 мянган төгрөг | Суурь үзүүлэлтээс доошгүй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй арга | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | В2 | ХДХВ, ДОХ-ын талаарх үндэсний бодлогын нийлмэл индекс | ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, тусламж үйлчилгээний үндэсний хариу арга хэмжээний ахиц дэвшлийн тайлан | Одоогоор байхгүй | |
| | Гарцын шалгуур үзүүлэлт | В3 | Ажлын байрны бодлого хөтөлбөртэй салбарын/ байгууллагын тоо | Байгууллагын үйл ажиллагааны ба хөтөлбөрийн тайлан | Одоогоор байхгүй | |
| | | В4 | Стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан өртөг тооцсон ажлын төлөвлөгөөтэй төрийн бус, иргэний нийгмийн байгууллагын эзлэх хувь | Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагад хийсэн үнэлгээ ба жилийн үйл ажиллагааны тайлан | Одоогоор байхгүй | |

## 1.2. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА

Хүснэгт 3

### A1. ЭРЧҮҮДТЭЙ БЭЛГИЙН ХАВЬТАЛД ОРДОГ ЭРЧҮҮДИЙН ДУНДАХ ХДХВ-ИЙН ХАЛДВАРТАЙ ХҮНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ

| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний дүн нь эерэг гарсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоог, ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд (ЭБЭ) - сүүлийн 12 сарын хугацаанд эрэгтэй хүнтэй шулуун гэдсээр болон амаар бэлгийн хавьталд орсон 15-аас дээш насны эрэгтэйчүүд. |
| Тооцох арга | $\frac{\text{ХДХВ} - \text{ийн халдвар илрүүлэх шинжилгээний дүн эерэг гарсан ЭБЭ} - \text{ийн тоо}}{\text{ХДХВ} - \text{ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан ЭБЭ} - \text{ийн тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2017 он - 9.2<br>- Зорилтот түвшин, 2021 он - 7.7% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн дундах ХДХВ-ийн халдварын тархалт, чиг хандлагыг тогтоох |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний дүн эерэг гарсан ЭБЭ-ийн тоо: ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан<br>- ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан ЭБЭ-ийн тоо: ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

Хүснэгт 4

## А2. ЭМЭГТЭЙ БИЕЭ ҮНЭЛЭГЧДИЙН ДУНДАХ ХДХВ-ИЙН ХАЛДВАРТАЙ ХҮНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ

| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний дүн нь эерэг гарсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоо, ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгаанд хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ) - сүүлийн 12 сарын хугацаанд тохиролцсоны үндсэн дээр бэлгийн хавьталд орохдоо мөнгө/бэлэг авсан 15-аас дээш насны эмэгтэйчүүд |
| Тооцох арга | $\frac{\text{ХДХВ − ын халдвар илрүүлэх шинжилгээний дүн эерэг гарсан ЭБҮ − ийн тоо}}{\text{ХДХВ − ын халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан ЭБҮ − ийн тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2017 он – 0%<br>- Зорилтот түвшин, 2021 он - 0.00% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | Эмэгтэй биеэ үнэлэгчдийн дундах ХДХВ-ийн халдварын тархалт, чиг хандлагыг тогтоох |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний дүн эерэг гарсан хүний тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан<br><br>- ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

## А3. МАНСУУРУУЛАХ БОДИС ТАРЬЖ ХЭРЭГЛЭГЧДИЙН ДУНДАХ ХДХВ-ИЙН ХАЛДВАРТАЙ ХҮНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ

| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний дүн нь эерэг гарсан мансууруулах бодис тарьж хэрэглэгчдийн тоог ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгаанд хамрагдсан мансууруулах бодис тарьж хэрэглэгчдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Мансууруулах бодис тарьж хэрэглэгч - мансууруулах бодисыг зүү, тариурын тусламжтай тараагуур судсанд, булчинд, арьсан дор тарьж хэрэглэдэг хүн. Зүү, тарилгын бусад хэрэгслийг дамжуулан хэрэглэснээр ХДХВ, гепатит зэрэг цусаар дамждаг вирусийн халдвар нэг хүнээс нөгөөд халдварлаж болдог. |
| Тооцох арга | $\frac{\text{ХДХВ} - \text{ийн халдвар илрүүлэх шинжилгээний дүн эерэг гарсан хүний тоо}}{\text{ХДХВ} - \text{ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | Тусгайлсан судалгаа хийгдээгүй |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | Мансууруулах бодис тарьж хэрэглэгчдийн дундах ХДХВ-ийн халдварын тархалт, чиг хандлагыг тогтоох |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний дүн эерэг гарсан хүний тоо:<br>Тусгайлсан судалгааны тайлан<br>- ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо:<br>Тусгайлсан судалгааны тайлан |
| Давтамж | |

## А4. ЭМЭГТЭЙ БИЕЭ ҮНЭЛЭГЧДИЙН ДУНДАХ ТЭМБҮҮГИЙН ХАЛДВАРЫН ТАРХАЛТ

| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Тэмбүүгийн халдвар баталгаажуулах шинжилгээний дүн нь эерэг гарсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоог тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ) - сүүлийн 12 сарын хугацаанд тохиролцсоны үндсэн дээр бэлгийн хавьталд орохдоо мөнгө/бэлэг авсан 15-аас дээш насны эмэгтэйчүүд |
| Тооцох арга | $\frac{\text{Тэмбүүгийн халдварын баталгаажуулах шинжилгээний дүн эерэг (RPR титр 1:2) гарсан хүний тоо}}{\text{Тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2017 он - 24.5%<br>- Зорилтот түвшин, 2021 он - 22.8% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | Бэлгийн эрсдэлт зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, тэмбүүгийн халдварын тархалт, чиг хандлагыг тогтоох |
| Мэдээллийн эх үүсвэр | - Тэмбүүгийн халдварын баталгаажуулах шинжилгээний дүн эерэг гарсан хүний тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан<br>- Тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

## А5. ЭРЧҮҮДТЭЙ БЭЛГИЙН ХАВЬТАЛД ОРДОГ ЭРЧҮҮДИЙН ДУНДАХ ТЭМБҮҮГИЙН ХАЛДВАРЫН ТАРХАЛТ

| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Тэмбүүгийн халдвар баталгаажуулах шинжилгээний дүн нь эерэг гарсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоог тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд (ЭБЭ) - сүүлийн 12 сарын хугацаанд эрэгтэй хүнтэй шулуун гэдсээр болон амаар бэлгийн хавьталд орсон 15-аас дээш насны эрэгтэйчүүд. |
| Тооцох арга | $\frac{\text{Тэмбүүгийн халдварын баталгаажуулах шинжилгээний дүн эерэг (RPR титр 1: 2) гарсан хүний тоо}}{\text{Тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2017 он - 24.5%<br>- Зорилтот түвшин, 2021 он - 22.8% |
| Задаргаа | – Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | Бэлгийн эрсдэлт зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, тэмбүүгийн халдварын тархалт, чиг хандлагыг тогтоох |
| Мэдээллийн эх үүсвэр | - Тэмбүүгийн халдварын баталгаажуулах шинжилгээний дүн эерэг гарсан хүний тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан<br>- Тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

## А6. ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТАД БУЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДУНДАХ ТЭМБҮҮГИЙН ХАЛДВАРЫН ТАРХАЛТ

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Тайлант онд тэмбүү илрүүлэх шинжилгээний хариу эерэг гарсан жирэмсэн эмэгтэйчүүдийг тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамрагдсан нийт жирэмсэн эмэгтэйчүүдэд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Жирэмсний хяналт - сургагдсан эрүүл мэндийн мэргэжилтний жирэмсэн эмэгтэйд үзүүлж буй тусламж, үйлчилгээ, энэ нь жирэмсний явцад эх болон ургийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой |
| Тооцох арга | $\frac{\text{Тэмбүүгийн халдварын баталгаажуулах шинжилгээний дүн эерэг гарсан жирэмсэн эмэгтэй тоо}}{\text{Тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйн тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2018 он - 2.4%<br>- Зорилтот түвшин, 2021 он - 2.0% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж:Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40-өөс дээш |
| Хэрэглээ | Нийт хүн амын дунд тэмбүүгийн халдварын тархалт, чиг хандлагыг тогтоох |
| Мэдээллийн эх үүсвэр | - Тэмбүүгийн халдварын баталгаажуулах шинжилгээний дүн эерэг гарсан жирэмсэн эмэгтэйн тоо:<br>Жилийн эцсийн эрүүл мэндийн статистик мэдээ, ЭМЯ, ЭМХТ<br>- Тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйн тоо:<br>Жилийн эцсийн эрүүл мэндийн статистик мэдээ, ЭМЯ, ЭМХТ |
| Давтамж | Жил бүр |

## А7. ХДХВ-ИЙН ХАЛДВАРГҮЙ 1000 ХҮН АМД НОГДОХ ХДХВ-ИЙН ШИНЭ ТОХИОЛДЛЫН ТОО

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | ХДХВ-ийн халдварын шинэ тохиолдлын тоог ХДХВ-ийн халдваргүй 1000 хүн амд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-ээр үүсгэгддэг архаг явцтай халдвар.<br>- Жилийн дундаж хүн амын тоо нь тайлант оны эхний болон эцсийн хүн амын тооны дунджаар илэрхийлэгдэнэ. |
| Тооцох арга | $\frac{\text{Шинээр бүртгэгдсэн ХДХВ} - \text{ийн тохиолдлын тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо} - \text{ХДХВ} - \text{ийн халдвартай хүний тоо}} * 1000$ |
| Хэмжих нэгж | Промиль |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2018 он - 0.01<br>- Зорилтот түвшин, 2021 он - 0.01 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 0-1 хүртэл, 1-4 нас, 5-9, 10-14, 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-49, 50-54, 55-59, 60-64, 65-69, 70-74, 75-79, 80-84, 85-аас дээш<br>- Хүйс: Эрэгтэй, эмэгтэй |
| Хэрэглээ | - ХДХВ, ДОХ-ын өвчлөл, тархалт өндөр нутаг, хүн амын бүлгийг тодорхойлох;<br>- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр, төслүүдийн ажлын үр дүнг үнэлэх;<br>- ХДХВ, ДОХ-ын эрт илрүүлэлт хийгээд эмчилгээний чанар, үр дүнг үнэлэх;<br>- ХДХВ, ДОХ-ын оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах нөөцийг оновчтой хуваарилах |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХДХВ-ийн халдварын шинэ тохиолдлын тоо:<br>Сар, жилийн эцсийн эрүүл мэндийн статистик мэдээ, ЭМЯ, ЭМХТ, ХӨСҮТ<br>- ХДХВ-ийн халдвартай хүний тоо:<br>Жилийн эцсийн эрүүл мэндийн статистик мэдээ, ЭМЯ, ЭМХТ, ХӨСҮТ<br>- Жилийн дундаж хүн амын тоо:<br>Жилийн эцсийн иргэний бүртгэлийн мэдээ, ҮСХ |
| Давтамж | Жил бүр |

| | |
|---|---|
| | |
| Тайлбар | Монгол Улс нь ХДХВ-ийн халдварын тархалт бага, жилд бүртгэгдэх тохиолдлын тоо харьцангуй цөөн тул тохиолдлын түвшинг тооцохдоо дундаж хүн амын тоогоор тооцоолно. |

## А8. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ТЭМБҮҮГИЙН ТОХИОЛДЛЫН ТҮВШИН

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Тайлангийн жилд 15-24 насны залуучуудын дунд шинээр бүртгэгдсэн тэмбүүгийн тохиолдлын тоог 10 000 хүн амд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Жилийн дундаж хүн амын тоо нь тайлант оны эхний болон эцсийн хүн амын тооны дунджаар илэрхийлэгдэнэ. |
| Тооцох арга | $\frac{15-24 \text{ насны тэмбүүгийн халдвартай хүний тоо}}{15-24 \text{ насны хүн амын тоо}} * 10000$ |
| Хэмжих нэгж | Продецимиль |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2018 он - 53.1<br>- Зорилтот түвшин, 2021 он - 50.0 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, бүс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Хүйс: Эрэгтэй, эмэгтэй<br>- Насны бүлэг: 15-19, 20-24 |
| Хэрэглээ | - Тэмбүүгийн өвчлөл, тархалт өндөр нутаг, хүн амын бүлгийг тодорхойлох;<br>- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр, төслүүдийн ажлынүр дүнг үнэлэх;<br>- Тэмбүү өвчний эрт илрүүлэлт, эмчилгээний чанар, үр дүнг үнэлэх;<br>- Тэмбүү өвчний оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах нөөцийг оновчтой хуваарилах;<br>- Тэмбүү өвчний хүн амын эрүүл мэнд, улс орны нийгэм, эдийн засагт учруулж буй дарамтыг тооцох; |
| Мэдээллийн эх үүсвэр | - 15-24 насны тэмбүүгийн халдвартай хүний тоо:<br>Жилийн эцсийн эрүүл мэндийн статистик мэдээ, ЭМЯ, ЭМХТ<br>- 15-24 насны хүн амын тоо:<br>Жилийн эцсийн иргэний бүртгэлийн мэдээ, УСХ |
| Давтамж | Жил бүр |

## А9. 15-34 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ДУНД ТҮГЭЭМЭЛ ТОХИОЛДОХ БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРЫН ТОХИОЛДЛЫН ТҮВШИН

| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Тайлангийн жилд 15-34 насны залуучуудын дунд шинээр бүртгэгдсэн бэлгийн замаар дамжих түгээмэл халдварын тохиолдлын тоог 10 000 хүн амд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Бэлгийн хавьтлаар дамжин тархдаг аливаа халдварыг бэлгийн замаар дамжих халдвар гэнэ. Бэлгийн замаар дамжих халдвар нь бэлгийн хавьталд ороогүй хүмүүсийн хооронд биеийн шингэн (цус, үрийн шингэн, утрээний шүүрэл г.м) солилцох үед мөн тархаж болно. Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварт тэмбүү, заг хүйтэн, трихомониазийн халдварыг оруулж тооцно.<br>- Жилийн дундаж хүн амын тоо нь тайлант оны эхний болон эцсийн хүн амын тооны дунджаар илэрхийлэгдэнэ. |
| Тооцох арга | $\frac{15-34 \text{ насны БЗДХ} - \text{ын халдвартай хүний тоо}}{15-34 \text{ насны хүн амын тоо}} * 10000$ |
| Хэмжих нэгж | Продецимиль |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2018 он - 197.9<br>- Зорилтот түвшин, 2021 он - 119.2 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, бүс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Хүйс: Эрэгтэй, эмэгтэй<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34 |
| Хэрэглээ | - БЗДХ, ХДХВ, ДОХ-ын өвчлөл, тархалт өндөр нутаг, хүн амын бүлгийг тодорхойлох;<br>- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр, төслүүдийн ажлынүр дүнг үнэлэх;<br>- БЗДХ, ХДХВ, ДОХ-ын эрт илрүүлэлт, эмчилгээний чанар, үр дүнг үнэлэх;<br>- БЗДХ, ХДХВ, ДОХ-ын оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах нөөцийг оновчтой хуваарилах;<br>- БЗДХ, ХДХВ, ДОХ-ын хүн амын эрүүл мэнд, улс орны нийгэм, эдийн засагт учруулж буй дарамтыг тооцох; |
| Мэдээллийн эх үүсвэр | - 15-34 насны БЗДХ-ын халдвартай хүний тоо:<br>Жилийн эцсийн эрүүл мэндийн статистик мэдээ, ЭМЯ, ЭМХТ<br>- 15-34 насны хүн амын тоо:<br>Жилийн эцсийн иргэний бүртгэлийн мэдээ, ҮСХ |
| Давтамж | Жил бүр |

## А10. ХДХВ-ИЙН ХАЛДВАР БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХААС СЭРГИЙЛЭХ АРГЫГ ЗӨВ ТОДОРХОЙЛЖ, ХДХВ-ИЙН ХАЛДВАРЫН ТАЛААРХ ТҮГЭЭМЭЛ ТАШАА ОЙЛГОЛТЫГ ҮГҮЙСГЭЖ ЧАДСАН ЭМЭГТЭЙ БИЕЭ ҮНЭЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийн асуултанд бүгдэд нь зөв хариулсан эмэгтэй бие үнэлэгчдийн тоог ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгаанд хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Эмэгтэй биеэ үнэлэгч - сүүлийн 12 сарын хугацаанд тохиролцсоны үндсэн дээр бэлгийн хавьталд орохдоо мөнгө/бэлэг авсан 15-аас дээш насны эмэгтэйчүүд |
| Тайлбар | ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийн асуулт нь дараах 5 асуултаас бүрдэнэ.<br>- Бэлгийн үнэнч, нэг хавьтагчтай байснаар ХДХВ-ийн халдвар дамжих эрсдэл буурах уу?<br>- Бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэснээр ХДХВ-ийн халдварын эрсдэлийг бууруулж чадах уу?<br>- Гаднаас нь харахад эрүүл хүн ХДХВ-ийн халдвартай байж болох уу?<br>- ХДХВ-ийн халдвар шумууланд хазуулахад дамжих уу?<br>- ХДХВ-ийн халдвартай хүнтэй гар барих, хоолоо хувааж идэхэд халдвар дамжих уу? |
| Тооцох арга | $\frac{\text{ХДХВ} - \text{ийн халдварын талаарх мэдлэгийн асуултанд бүгдэд нь зөв хариулсан ЭБҮ} - \text{ийн тоо}}{\text{Судалгаанд хамрагдсан ЭБҮ} - \text{ийн тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтоттүвшин | - Суурь түвшин, 2017 он - 25.3<br>- Зорилтот түвшин, 2021 он - 29.6 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | Эмэгтэй бие үнэлэгчдийн ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийн асуултад бүгдэд нь зөв хариулсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоо: ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан<br>- ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгаанд хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоо: ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

Хүснэгт 13

### A11. ХДХВ-ИЙН ХАЛДВАР БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХААС СЭРГИЙЛЭХ АРГЫГ ЗӨВ ТОДОРХОЙЛЖ, ХДХВ-ИЙН ХАЛДВАРЫН ТАЛААРХ ТҮГЭЭМЭЛ ТАШАА ОЙЛГОЛТЫГ ҮГҮЙСГЭЖ ЧАДСАН ЭРЧҮҮДТЭЙ БЭЛГИЙН ХАВЬТАЛД ОРДОГ ЭРЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийн асуултанд бүгдэд нь зөв хариулсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоог ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд - сүүлийн 12 сарын хугацаанд эрэгтэй хүнтэй шулуун гэдсээр болон амаар бэлгийн хавьталд орсон 15-аас дээш насны эрэгтэйчүүд. |
| Тайлбар | ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийн асуулт нь дараах 5 асуултаас бүрдэнэ.<br>- Бэлгийн үнэнч, нэг хавьтагчтай байснаар ХДХВ-ийн халдвар дамжих эрсдэл буурах уу?<br>- Бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэснээр ХДХВ-ийн халдварын эрсдэлийг бууруулж чадах уу?<br>- Гаднаас нь харахад эрүүл хүн ХДХВ-ийн халдвартай байж болох уу?<br>- ХДХВ-ийн халдвар шумууланд хазуулахад дамжих уу?<br>- ХДХВ-ийн халдвартай хүнтэй гар барих, хоолоо хувааж идэхэд халдвар дамжих уу? |
| Тооцох арга | $\frac{\text{ХДХВ − ийн халдварын талаарх мэдлэгийн асуултанд бүгдэд нь зөв хариулсан ЭБЭ − ийн тоо}}{\text{Судалгаанд хамрагдсан ЭБЭ − ийн тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2017 он - 55.6<br>- Зорилтот түвшин, 2021 он - 57.7 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийн асуултанд бүгдэд нь зөв хариулсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |

| | |
|---|---|
| | - ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

**А12. СҮҮЛИЙН 12 САРЫН ХУГАЦААНД ХДХВ-ИЙН ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДАЖ, ШИНЖИЛГЭЭНИЙХЭЭ ХАРИУГ МЭДЭЖ БАЙГАА ЭМЭГТЭЙ БИЕЭ ҮНЭЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ**

| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ-ийн халдварын шинжилгээнд хамрагдан, хариугаамэдэж байгаа эмэгтэй бие үнэлэгчдийн тоог ХДХВ, БЗДХ-ын судалгаанд хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Эмэгтэй биеэ үнэлэгч - сүүлийн 12 сарын хугацаанд тохиролцсоны үндсэн дээр бэлгийн хавьталд орохдоо мөнгө/бэлэг авсан 15-аас дээш насны эмэгтэйчүүд |
| Тайлбар | ХДХВ-ийн халдварын шинжилгээнд хамрагдсан талаарх асуулт нь дараах 2 асуултаас бүрдэнэ.<br>- Та сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн үү?<br>- Хэрэв тийм бол шинжилгээний хариугаа мэдэж байгаа юу? |
| Тооцох арга | $\frac{\text{ХДХВ − ийн шинжилгээнд хамрагдан, хариугаа мэдэж байгаа ЭБҮ − ийн тоо}}{\text{Судалгаанд хамрагдсан ЭБҮ − ийн тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2017 он - 76.4<br>- Зорилтот түвшин, 2021 он - 84.2 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүртээмжийг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХДХВ-ийн халдварын шинжилгээнд хамрагдан, хариугаа мэдэж байгаа эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан<br>- ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгаанд хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

**А13. СҮҮЛИЙН 12 САРЫН ХУГАЦААНД ХДХВ-ИЙН ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДАЖ, ШИНЖИЛГЭЭНИЙХЭЭ ХАРИУГ МЭДЭЖ БАЙГАА ЭРЧҮҮДТЭЙ БЭЛГИЙН ХАВЬТАЛД ОРДОГ ЭРЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ**

| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ-ийн халдварын шинжилгээнд хамрагдан, хариугаа мэдэж байгаа эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоог ХДХВ, БЗДХ-ын судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд (ЭБЭ) - сүүлийн 12 сарын хугацаанд эрэгтэй хүнтэй шулуун гэдсээр болон амаар бэлгийн хавьталд орсон 15-аас дээш насны эрэгтэйчүүд. |
| Тайлбар | ХДХВ-ийн халдварын шинжилгээнд хамрагдсан талаарх асуулт нь дараах 2 асуултаас бүрдэнэ.<br>- Та сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн үү?<br>- Хэрэв тийм бол шинжилгээний хариугаа мэдэж байгаа юу? |
| Тооцох арга | $\frac{\text{ХДХВ} - \text{ийн шинжилгээнд хамрагдан, хариугаа мэдэж байгаа ЭБЭ} - \text{ийн тоо}}{\text{Судалгаанд хамрагдсан ЭБЭ} - \text{ийн тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2017 он - 87.7<br>- Зорилтот түвшин, 2021 он - 95.0 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүртээмжийг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХДХВ-ийн халдварын шинжилгээнд хамрагдан, хариугаа мэдэж байгаа эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан<br>- ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

## А14. ХДХВ-ИЙН ХАЛДВАР БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХААС СЭРГИЙЛЭХ АРГЫГ ЗӨВ ТОДОРХОЙЛЖ, ХДХВ-ИЙН ХАЛДВАРЫН ТАЛААРХ ТҮГЭЭМЭЛ ТАШАА ОЙЛГОЛТЫГ ҮГҮЙСГЭЖ ЧАДСАН 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ

| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийн асуултанд бүгдэд нь зөв хариулсан 15-24 насны залуучуудын тоог ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгаанд хамрагдсан 15-24 насны залуучуудын тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Өсвөр үе 15-19 нас<br>- Залуучууд 20-24 нас |
| Тайлбар | ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийн асуулт нь дараах 5 асуултаас бүрдэнэ.<br>- Бэлгийн үнэнч, нэг хавьтагчтай байснаар ХДХВ-ийн халдвар дамжих эрсдэл буурах уу?<br>- Бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэснээр ХДХВ-ийн халдварын эрсдэлийг бууруулж чадах уу?<br>- Гаднаас нь харахад эрүүл хүн ХДХВ-ийн халдвартай байж болох уу?<br>- ХДХВ-ийн халдвар шумууланд хазуулахад дамжих уу?<br>- ХДХВ-ийн халдвартай хүнтэй гар барих, хоолоо хувааж идэхэд халдвар дамжих уу? |
| Тооцох арга | $\frac{\text{ХДХВ} - \text{ийн халдварын талаарх мэдлэгийн асуултанд бүгдэд нь зөв хариулсан } 15-24 \text{ насны залуучуудын тоо}}{\text{Судалгаанд хамрагдсан } 15-24 \text{ насны залуучуудын тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | Суурь түвшин, 2018 он:<br>- Эрэгтэй-20.2<br>- Эмэгтэй-20.2 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24<br>- Хүйс: Эрэгтэй, эмэгтэй |
| Хэрэглээ | Залуучуудын ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, ҮСХ |
| Давтамж | 5 жил тутам |

Хүснэгт 17

## А15. ШИНЭЭР ОНОШЛОГДСОН СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨНҮҮДИЙН ДУНД ХДХВ-ИЙН ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ӨВЧТӨНҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Тайлант онд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо (шинээр оношлогдсон сүрьеэтэй өвчтөн)-г шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | Сүрьеэ өвчин нь сүрьеэгийн нянгаар үүсгэгддэг амьсгалын замын халдварт өвчин. |
| Тооцох арга | $\frac{\text{ХДХВ} - \text{ийн халдвар илрүүлэх шинжилгээ хамрагдсан хүний тоо (шинээр оношлогдсон сүрьеэтэй өвчтөн)}}{\text{Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2018 он - 98.7<br>- Зорилтот түвшин, 2021 он - 99.0 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40-өөс дээш<br>- Хүйс: Эрэгтэй, эмэгтэй |
| Хэрэглээ | Сүрьеэтэй өвчтөнүүдийн ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдалтыг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан шинээр оношлогдсон сүрьеэтэй өвчтөний тоо:<br>Жилийн эцсийн эрүүл мэндийн статистик мэдээ, ХӨСҮТ<br>- Сүрьеэгийн шинэ тохиолдлын тоо:<br>Жилийн эцсийн эрүүл мэндийн статистик мэдээ, ХӨСҮТ |
| Давтамж | Жил бүр |

## A16. СҮҮЛИЙН УДАА ЭРЭГТЭЙ ХҮНТЭЙ ХОШНОГООР БЭЛГИЙН ХАВЬТАЛД ОРОХДОО БЭЛГЭВЧ ХЭРЭГЛЭСЭН ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн эрчүүдийн тоог сүүлийн 6 сарын хугацаанд хавьталд орсон эрчүүдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд гэдэг нь эрэгтэй хүнтэй хошногоор бэлгийн хавьталд ордог эрчүүд |
| Тооцох арга | $\frac{\text{Хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоо}}{\text{Сүүлийн 6 сард бэлгийн хавтлалд орсон ЭБЭ − ийн тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2017 он - 78.5<br>- Зорилтот түвшин, 2021 он - 83.0 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40-өөс дээш |
| Хэрэглээ | Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн дунд хамгаалалтгүй бэлгийн хавьталд ороход ХДХВ-ийн халдвар авах эрсдэлд ямар нэгэн ахиц гарч байгааг тандах |
| Мэдээллийн эх үүсвэр | - Сүүлийн удаа эрэгтэй хүнтэй хошногоор бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн эрэгтэйчүүдийн эзлэх хувь<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

Хүснэгт 19

**А17. СҮҮЛИЙН УДАА ҮЙЛЧЛҮҮЛЭГЧТЭЙГЭЭ БЭЛГИЙН ХАВЬТАЛД ОРОХДОО БЭЛГЭВЧ ХЭРЭГЛЭСЭН ЭМЭГТЭЙ БИЕЭ ҮНЭЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ**

| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Сүүлийн удаа үйлчлүүлэгчтэйгээ бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоог сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | Эмэгтэй биеэ үнэлэгч гэдэг нь бэлгийн хавьталд орохдоо ямар нэгэн шан харамж авдаг эмэгтэйчүүд |
| Тооцох арга | $\frac{\text{Хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоо}}{\text{Сүүлийн 12 сард бэлгийн хавталд орсон ЭБҮ} - \text{ийн тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2017 он - 85.1<br>- Зорилтот түвшин, 2021 он - 90.0 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40-өөс дээш |
| Хэрэглээ | - Эмэгтэй биеэ үнэлэгчдийн дунд хамгаалалтгүй бэлгийн хавьталд ороход ХДХВ-ийн халдвар авах эрсдэлд ямар нэгэн ахиц гарч байгааг тандах |
| Мэдээллийн эх үүсвэр | - Сүүлийн удаа үйлчлүүлэгчтэйгээ бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн эмэгтэй биеэ үнэлэгчдийн эзлэх хувь<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

## А18. ХДХВ-ИЙН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ЭМЭГТЭЙ БИЕЭ ҮНЭЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | ХДХВ-ийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдээс асуусан асуултад бүгдэд нь “Тийм” гэж хариулсан эмэгтэй бие үнэлэгчдийн тоог ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгаанд хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ) - сүүлийн 12 сарын хугацаанд тохиролцсоны үндсэн дээр бэлгийн хавьталд орохдоо мөнгө/бэлэг авсан 15-аас дээш насны эмэгтэйчүүд.<br>- Урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан гэдэг нь эрсдэлт өндөртэй бүлэгт үйлчилдэг ТББ-аас үйлчилгээ авсан тухайн олон нийтийн хүнийг хэлнэ. Тус үйлчилгээнд тухайн байгууллагаас БЗДХ, ХДХВ, БЗДХ-оос урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, гарын авлага авч, шинжилгээ, зөвлөгөөнд хамрагдан хариугаа авсан, бэлгэвч, чийгшүүлэгч авсан зэрэг орно. |
| Тайлбар | - ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдээс асуух асуулт нь дараах 2 асуултаас бүрдэнэ.<br>- Та ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэхээр бол хаана очихоо мэдэх үү?<br>- Та сүүлийн 12 сард үнэгүй тараагдсан бэлгэвч авсан уу? |
| Тооцох арга | $\frac{\text{Дээрх асуултанд бүгдэд нь тийм гэж хариулсан ЭБҮ} - \text{ийн тоо}}{\text{Судалгаанд хамрагдсан ЭБҮ} - \text{ийн тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2017 он - 55.2<br>- Зорилтот түвшин, 2021 он - 83.4 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хамралтыг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХДХВ-ийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдээс асуултад бүгдэд нь “Тийм” гэж хариулсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |

| | |
|---|---|
| | - ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгаанд хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоо:<br>ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгааны тайлан |
| Давтамж | 2 жил тутам |

## A19. ХДХВ-ИЙН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ЭРЧҮҮДТЭЙ БЭЛГИЙН ХАВЬТАЛД ОРДОГ ЭРЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

| Үзүүлэлтийн төрөл | Гарцын шалгуур үзүүлэлт (Урьдчилан сэргийлэлт) |
|---|---|
| Үзүүлэлтийн тодорхойлолт | ХДХВ-ийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан ЭБЭ-ээс асуусан асуултад бүгдэд нь "Тийм" гэж хариулсан ЭБЭ-ийн тоог ХДХВ, БЗДХ-ын тандалтын судалгаанд хамрагдсан ЭБЭ-ийн тоонд харьцуулсан үзүүлэлт |
